



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн
засгийн үндсэн үзүүлэлт болон зорилтот түвшин,
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Д.Энхтөмөртэй байгуулсан контрактын биелэлтийг “Хангалтгүй” гэж дүгнэсүгэй.

2. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Энхтөмөртэй байгуулсан контрактын гэрээг дуусгавар болгох, үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

300515